

242



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1990 оны 5 дугаар
сарын 27-ний өдөр

дугаар 104

Улаанбаатар

хот

Нийтийн аж ахуй үйлчилгээний яам татан буугдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Нийтийн аж ахуй үйлчилгээний яам татан буугдсантай холбогдуулан Нийтийн аж ахуй үйлчилгээний яамны авто бааз, Лицт засвар үйлчилгээний конторыг Улаанбаатар хотын нийтийн аж ахуй үйлчилгээний авто бааз, Улаанбаатар хотын Лицт-засвар үйлчилгээний контор болгон өөрчилж хуучин гүйцэтгэж байсан ажил үүргийг нь хэвээр үлдээн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяанд ажиллуулж Орон сууц, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан орлогч даргад хариуцуулан 1990 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2. Нийтийн аж ахуй үйлчилгээний автобааз /н.Хадхүрэл/-д ДААЛГАХ нь:

а/ тусгай төхөөрөмжтэй ГАЗ-52 маркийн автомашиныг 3 ээлжийн жолоочийн цалингийн фондын хамт Лицт засвар үйлчилгээний конторт энэ оны 6 дугаар сарын 1-ний дотор шилжүүлэх;


б/ хотын хэмжээнд албан байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулж бололцооны хирээр үйлчилгээний хүрээг өргөтгөн 1990 оны төлөвлөгөөт даалгаврыг хугацаанд нь биелүүлэх арга хэмжээ авах;

3. Нийтийн аж ахуй үйлчилгээний яамны Барилга захиалагчийн товчоог Улаанбаатар хотын Барилга захиалагчийн товчоотой 1990 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн нэгтгэж ажиллуулсугай.

2.

4. Улаанбаатар хотын сургууль, цэцэрлэг, ясли, эмнэлэг зэрэг үйлчилгээний байгууллага, орон сууцыг халаадаг усан халаалтын зуух, шугам сүлжээ, ажиллах хүч, машин тоног төхөөрөмж сэлбэг хэрэгслэлийг 1990 оны 6 дугаар сарын 15-ны дотор Дулааны шугам сүлжээний газарт шилжүүлэн хүлээлцэхийг Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар /н.Пүрэвхүү/, Дулааны шугам сүлжээний газар /н.Аюурсэд/-т үүрэг болгосугай.

5. Нийтийн аж ахуй үйлчилгээний авто бааз, лифть засвар үйлчилгээний конторын орон тоо, зохион байгуулалт, харьяалал өөрчлөгдсөнтэй холбогдуулж 1990 оны төлөвлөгөө, төсөвт зохих өөрчлөлт хийхийг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Төлөвлөгөө эдийн засгийн хэлтэс /н.Бат/, Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЭЛГЭДТЭЙ
ХҮРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА

Л.ЭНЭБИШ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.АЛГИА